

# **ДЭД БҮТЦИЙН СТАНДАРТЫН ГАРЫН АВЛАГА**

*/MNS 6055:2009, MNS 6056:2009/*

Улаанбаатар хот  
2019 он

**Хянасан:**

*Хөгжил, нийгмийн оролцооны газрын дарга С.Баярбат*

**Боловсруулсан:**

*Хөгжил, нийгмийн оролцооны газрын мэргэжилтэн Ц.Болормаа*

## ӨМНӨХ ҮГ

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг аливаа ялгаваргүйгээр нийгмийн харилцаанд тэгш оролцуулах, бие даан амьдрах боломжийг бүрдүүлэх, амьдралын чанарыг нь сайжруулахад нөлөөлөх, хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг эерэгээр төлөвшүүлэх зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Монгол улс 2009 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцид нэгдэн, 2014 онд Ази, номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратегийг хүлээн авч, 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг баталсан. Мөн 2017 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна.

Эдгээр эрх зүйн баримт бичгийн үндсэн санаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг баталгаажуулах, бие даан амьдрах нөхцлийг бүрдүүлэх, амьдарлын чанарыг сайжруулахад оршиж байгаа юм.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар Монгол улсын хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар 105691 хөгжлийн бэрхшээлтэй хүн амьдарч байгаагаас 21598 нь хөдөлгөөний бэрхшээлтэй, 11519 нь харааны бэрхшээлтэй хүн байна.

Стандартчилал, хэмжилзүйн үндэсний зөвлөлийн 2009 оны 51 дүгээр тогтоолоор “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага /MNS 6055:2009/, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар /MNS 6056:2009/ стандартууд батлагдсан. Хэдийгээр стандарт байдаг ч хэрэгжилт нь төдийлөн хангалтгүй байсаар байна.

Сүүлийн жилүүдэд их бүтээн байгуулалт өрнөж, зам талбай дэд бүтцийн асуудал ихээр яригдаж, хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагад нийцсэн дэд бүтэц, орчны стандартыг хангасан барилга байгууламж ховор, дийлэнхэд нь стандарт мөрдөгдөөгүйгээс

тэдэнд, тэр дундаа хөдөлгөөний болон харааны бэрхшээлтэй хүмүүст ихээхэн хүндрэл учруулснаас нийгмийн харилцаанд оролцох, бие даан амьдрах нөхцөл боломж нь хязгаарлагдмал байгаа.

Тиймээс /MNS 6055:2009/, /MNS 6056:2009/ стандартыг энгийн байдлаар тайлбарлан гарын авлага боловсруулан хэрэглэгч нарт хүргэж байна.

Энэхүү гарын авлагыг зөвхөн мэргэжлийн байгууллага гэлтгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орчинг бүрдүүлэх шаардлагатай аль ч байгууллага, хувь хүн ашиглах боломжтой юм..

---


**ИРГЭНИЙ БАРИЛГЫН ТӨЛӨВЛӨЛТӨД ХӨГЖЛИЙН  
БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ШААРДЛАГЫГ ТООЦСОН  
ОРОН ЗАЙ, ОРЧИН. ҮНДСЭН ШААРДЛАГА**

*/MNS 6055 : 2009/*

---

## БАРИЛГА, ӨРӨӨ ТАСАЛГААНЫ ОРЦ БОЛОН ХААЛГА

Иргэний зориулалттай (орон сууц, олон нийт) барилгад хөгжлийн бэрхшээлтэй хүн орох боломжийг хангасан налуу зам болон бусад тоног төхөөрөмжүүдээр заавал тоноглогдсон байна.



- 1- Хаалганы код байрлуулах бүс
- 2- Тоон тэмдэг бүхий давхрын дугаар
- 3- Дуудах хонх


### ***Давхрын дугаар:***

Шалнаас 1,4 м -1,6 м өндөрт товойлгон дүрслэх

### ***Хаалганы код, хонх:***

Шалнаас 80 см -1,1 м өндөрт байрлах

Барилга, өрөө тасалгааны гол хаалга нь хөгжлийн бэрхшээлтэй хүн ашиглах боломжтой 85 см-ээс багагүй өргөнтэй, орон зай нь уужим цэлгэр байна.



**Хаалганы бариул:**


- Шалнаас дээш 90 см-100 см,
- Урд ирмэгээс хойш 20 см

**Хаалганы хэмжээ:**

- Босгоны өндөр  $\leq 2,5$  см, эсвэл босгогүй байх
- Хаалганы өргөн  $\geq 85$  см



Шилэн хаалга нь автоматаар онгойж дэлгэгддэг, эсвэл хавтастай байж болно. Шилэн хаалгыг ашиглах үед харааны бэрхшээлтэй хүнд зориулж, хаалган дээр анхааруулах өнгөт зурвасыг хэвтээ чиглэлд зурж тэмлэглэнэ.



Анхааруулах зурвасыг шалнаас дээш 1,6 м-ийн өндөрт 15 см-ийн өргөнтэйгээр **тод өнгөөр** тэмдэглэнэ.






## НАЛУУ ЗАМ (ПАНДУС)

Налуу шатны стандартаар өндрийн хэмжээ хамгийн ихдээ 0,12 м байх тохиолдолд уртын хэмжээ 1 м байхаар тооцно.

Өндрийг-  $h$ , Уртыг-  $l$  үсгээр тэмдэглэв.

Налуу замын уртыг олох томъёо:  $\frac{l}{h} = \frac{1}{0.12}$



### Жишээ нь:


Шатны өндөр 90 см тохиолдолд налуу шатны урт нь 7,5 м байна.

$$\frac{l}{h} = \frac{1}{0.12}; \quad \frac{1}{0.12 \text{ м}} = \frac{x}{90 \text{ см}};$$

$$x = \frac{90 \text{ см} * 1}{12 \text{ см}} = 7,5 \text{ м};$$



Налуу замын эхлэл, төгсгөлд тэгш талбай байгуулах ба түүний урт нь налуу зам (пандус)-ын өргөнөөс багагүй байна. Налуу замын өргөн 1,2 м-ээс багагүй байна. Урт хийгдэх тохиолдолд замын чиглэлийг өөрчлөн дугуйрсан байдлаар хийж, налуу замын дугуйрах хэсэг тэргэнцэр эргэх боломжтой буюу 1.5 м-ээс багагүй байна.




**Жишээ нь:**

7 м 50 см урт налуу замын 3 дахь метрээс эхлэн тойрог үүсгэе:


$l * 0.12; 3\text{м} * 0.12\text{ м} = 0.36\text{ м болж байна.}$

Тэгвэл өндөр 0,36 м бол налуу замын урт 3 м болно.

$$\frac{1}{0.12\text{ м}} = \frac{x}{0.36\text{ м}}; \quad x = \frac{36\text{ см} * 1}{12\text{ см}} = 3\text{ м};$$



Налуу замын 2 хажуу талаар 90 см-ээс багагүй өндөрт бариул бүхий хашлагыг хийнэ. Бариулыг 2 эгнээгээр байрлуулж, тэдгээрийн өндөр нь 70 см ба 90 см байна. Налуу замын бариулын хийц шатны бариулын хийцтэй адилхан байна. Сургуулийн өмнөх насныханд зориулж 50 см өндөрт бариул төлөвлөж болно.





## ШАТ

Барилга байгууламжийн гаднах шатны гишгүүрийн өргөн 40 см-ээс багагүй, дотор шатанд 30 см-ээс багагүй, гишгүүрийн өндөр гадна шатанд 12 см-ээс ихгүй, дотор шатанд 15 см-ээс ихгүй байна.

Дотор шатны бариул дээр харааны бэрхшээлтэй хүнд зориулж, брайль тэмдэглэгээгээр, эсвэл крилл тоог товойлгон давхрын тоо болон анхааруулах бичиглэл хийж, шатны эхлэл төгсгөлийг **тод өнгөөр** ялгаж өгнө.




Шатны үргэлжилсэн гишгүүрийн доор 2,1 м-ээс багагүй өндөртэй бүсэд сэрэмжлүүлэх хашилт, хаалтыг байрлуулна. Мөн шатны эхлэл, төгсгөлд анхааруулах товрууг хийж өгнө.



### **Харааны бэрхшээлтэй хүнд зориулсан зам, ханын бариул**

Барилга байгууламжийн дотор болон гадна талд харааны бэрхшээлтэй хүнд зориулсан брайль замыг хийх шаардлатай.

Байгууллагын дотор талд хийх тохиолдолд байгууллагын үүднээс мэдээлэл лавлагааны хэсэг хүртэл болон өрөө тасалгааны бүх чиглэлд брайль зам хийж болно. Эсвэл ханын дагуу бариул хийнэ.



Ханын бариулыг хийх тохиолдолд 75 см-ийн өндөрт 8 см-ээс илүүгүй өргөнтэй бариулыг хана дагуулж хийнэ.






## АРИУН ЦЭВЭР-ЭРҮҮЛ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ ӨРӨӨ


Ариун цэврийн өрөөнд тэргэнцэртэй хүнд зориулсан нэгээс доошгүй тасалгааг төлөвлөх ба түүний хамгийн бага хэмжээ нь 1.65м × 1.8м байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн тэргэнцрээс суултуур дээр шилжин суух боломжийг хангахын тулд ариун цэврийн өрөө (кабин)-д байгаа суултуурын хажуу хэсэгт тэргэнцэр байршуулах чөлөөт орон зай (талбай)-г гаргана.

3




Нийтийн бие засах өрөөг тулгуур, таяг болон бусад тоног, хэрэгсэл ашигладаг хүнд зориулж, хажуугийн хана, дагуулсан бариул, хувцасны өлгүүр, бусад хамрагдах тоноглолын хамт тохижуулна.



## Угаалтуур

Нийтийн бие засах өрөөний гар угаах хэсэгт нэгээс цөөнгүй тосгуурыг шалнаас 80 см-ээс ихгүй өндөрт, хажуугийн хананаас 20 см-ээс багагүй зайд толь, гар хатаах төхөөрөмж болон гарын алчуур хатаах өлгүүрийг шалнаас 90 см-ээс ихгүй өндөрт байршуулна.



Угаалтуур нь тэргэнцэртэй хүнд зориулагдсан өндөр нь 80 см-ээс ихгүй байна.




## ЗОРИУЛАЛТЫН БҮСЧЛЭЛ

### Лангуу

Үйлчилгээний тавцан /лангуу/-г одой хүн болон тэргэнцэртэй хүний орон зайг тооцоолж, хангалттай хэмжээнд байрлуулна. Тэргэнцэртэй хүнд зориулж лангууны дэргэд тусгай талбай гарган шалны түвшинг хангалттай өндөрсгөнө.

Тавцангийн өндөр нь 70 см, өргөн нь 1 м, тавцангийн тэргэнцэр орох зай нь 50 см байна.



Тухайн лангууны тавцанг бүхэлд нь намхан хийх шаардлагагүй бөгөөд аль нэг хэсгийг намхан /тэргэнцэртэй хүнд хүртээмжтэй/ болгож төлөвлөж болно.





---

**ЯВГАН ХҮН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД  
ЗОРИУЛСАН ЗАМЫГ ТӨЛӨВЛӨХ ЗААВАР**

*/MNS 6056 : 2009/*

---

## ЯВГАН ХҮНИЙ ЗОРЧИХ ЧӨЛӨӨ

Гудамжны дагуух эсвэл гудамжны булангийн хооронд байрлах автомашины замын хашлагаас барилга байгууламжийн нүүр хэсэг хүртэлх зайг **Явган хүний зорчих чөлөө** гэнэ.

Явган хүний зам нь дараах шинж чанарыг агуулсан байна.

### Үүнд:

- Явган зорчигчийн хэсэг, ногоон байгууламж, үйлчилгээ, барилга байгууламжийн нүүр хэсэг тодорхой
- Саад болох биет бага
- Ил цухуйсан мөргөцөг маш бага
- Төвшингийн зөрүү бага
- Жигд, тогтвортой, халтиргаанаас хамгаалсан гадаргуутай
- Гэрэлтүүлэг сайтай

### Явган хүний зорчих чөлөөний бүтэц:

Хэсгийн нэр	Хамгийн бага өргөн / см
Замын хашлага	8/15 см
Ногоон байгууламж /тохижилтын хэсэг/	61 см
Явган хүний зам	150 см
Барилга, байгууламжийн нүүр хэсэг	76 см
<b>Явган хүний зорчих чөлөөний өргөн</b>	<b>310 см</b>



## Явган хүний замын өргөн


Тэргэнцрийн хамгийн их өргөн 71 см байдаг учир явган хүний замын өргөн хамгийн багадаа 91.5 см байна. Гэхдээ үүнд явган зорчигчдын 2 эгнээ урсгал, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг дагуулж яваа хүн, эсвэл нохой зэргийг тооцоолоогүй. Энэхүү хамгийн бага өргөний хэмжээг дараах тохиолдолд зөвшөөрч болно.

### Үүнд:

- Явган хүний замыг илүү өргөн болгох боломжгүй
- Замын нарийссан хэсэг богино зайд үргэлжилсэн
- Зөрөх хэсгүүд 61 см-ээс илүүгүй зайд үргэлжилсэн




Нарийн зам дээр хамгийн багадаа 61 см тутамд тэргэнцэр зөрөх зайг хийж өгнө. Замын налуу хавтанг автомашины зам руу сунгана. Явган замын зорчих хэсэгт ил цухуйсан мөргөцөг, аливаа саадыг зайлуулах шаардлагатай.



### **Замын налуу хавтан**

Налуу хавтан нь тэргэнцэртэй зорчигч явган хүний замаас гудамжинд шилжих боломжийг олгодог хамгийн чухал хэрэглүүр юм. Налуу хавтанг уулзвараас гадна гудамжин дахь машины зогсоол, ачиж буулгах хэсэг, автобусны буудал, хорооллын дундах гарц зэрэгт хийдэг.

Автомашины гарцтай хэсэгт явган хүний замыг 2%-ийн налуутай хийнэ.




## Харааны бэрхшээлтэй хүнд зориулсан зам

Харааны бэрхшээлтэй хүн нь явган хүний замаар зорчихдоо автомашины замын чимээ, замын налуу хашлага, барилга байшин, мөн өөрийн явсан зам болон хүрэх газар хоорондын зайгаар баримжаалан чиглэлээ олж явдаг.





## Хөтөч хавтан

Хөтөч хавтан нь харааны бэрхшээлтэй зорчигч замаа олохыг мэдээлдэг. Энэ нь гадаа, хөндлөн гарц, барилга байгууламжийн дотор зэрэг газар хэрэглэгдэнэ. Барилга байгууламжийн дотор байрлуулсан зам нь уян хатан чанартай материалаар буюу резинэн материалаар хийгдвэл илүү тохиромжтой.




## Анхааруулах товруутай гадаргуу

Анхааруулах товруутай гадаргууг харааны бэрхшээлтэй зорчигч гудамжруу орохоос өмнө анхааруулах зорилгоор замын төгсгөл, гарц зэрэгт байрлуулдаг. Анхааруулах товруутай гадаргууг хэт өндөр, эсвэл жигд бус өндөртэй суурилуулбал тэргэнцэртэй, таягтай зорчигчид тэнцвэрээ алдахад хүргэдэг.



Товруутай гадаргууг замын налууны доод хэсэг, хашлаганы ирмэгээс 15,2 см - 20 см-ийн зайд дараах байрлалд суурилуулна.

- Замын булангийн гарц
- Төвшингийн өөрчлөлттэй газар
- Гарцын налуу хэсэгт
- Тусгаарлах аралтай хэсэгт
- Галт тэргэнд суух шижих тавцангийн ирмэг дээр





## Явган хүний замын гэрэлтүүлэг


Явган зорчигчдод зориулсан хамгийн сайн гэрэлтүүлэг нь явган хүний замыг гэрэлтүүлэх зорилгоор доошоо тусгалтай байх ёстой. Энэ нь замыг зөвхөн гэрэлтүүлэх төдийгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлдэг. Гэрэлтүүлгийг гэрэл ойлгогч материалтай хослуулах нь хамгийн сайн үр дүнтэй юм.



## Автомашинны зогсоол

Нийт авто зогсоолын 4%-д нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан авто зогсоолыг төлөвлөж, тэмдэг тэмдэглэгээг байршуулна.


Зогсоолыг төлөвлөхдөө 3,5м х 5м -ийн харьцаатай хийж, цэнхэр өнгөөр ялгаж өгөх ба зогсоолын голд цагаан өнгөөр тэргэнцрийн дүрсийг байршуулна.



**Стандарт /хүртээмжтэй/ болон стандарт бус /хүртээмжгүй/  
дэд бүтцийн байгууламжийн ялгаа**



**Ариун цэврийн өрөө**






# Стандарт /хүртээмжтэй/ болон стандарт бус /хүртээмжгүй/ дэд бүтцийн байгууламжийн ялгаа



## Налуу зам



## Шат



**Стандарт /хүртээмжтэй/ болон стандарт бус /хүртээмжгүй/  
дэд бүтцийн байгууламжийн ялгаа**



**Явган хүний зам**



**Хаалга**





